

## ЭРДЭМТЭН С.ИШДОРЖИЙН 75 НАСНЫ ОЙ

2003 оны 11-р сард ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн ахмад дипломатч, эрдэмтэн С.Ишдоржийн 75 насны ойг тэмдэглэв. Ойг тэмдэглэхэд УИХ-ын гишүүн, академич Б.Чадраа, ШУА-ийн ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч, доктор Т.Галбаатар, Олон улс судлалын хүрээлэнгийн захирал, доктор Л.Хайсандай зэрэг хүмүүс оролцов.

Эрдэмтэн С.Ишдорж 50-иад оны эхээр Москва хотын Олон улсын харилцааны дээд сургуулийг олон улсын харилцааны түүхч мэргэжлээр төгсч, 1972 онд ЗХУ-ын КН-ын дэргэдэх Нийгмийн Ухааны Академид дэд докторын зэрэг хамгаалсан манай улсын анхны мэргэжлийн дипломатч, эрдэмтэн билээ. С.Ишдорж ГХЯ, МАХН-ын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлд хариуцлагатай алба хашиж байгаад 1970-аад оны дундуур ШУА-д Дорнодахины судлалын хүрээлэнд /Одоогийн Олон улс судлалын хүрээлэн/ эрдэм шинжилгээний ажилтан, тасгийн эрхлэгч, сэтгүүлийн эрхлэгчээр олон жил идэвхи зүтгэлтэй ажиллаж байгаад тэтгэвэртээ гарсан ахмад эрдэмтэн билээ.

С.Ишдорж 70, 80-аад онд “Монгол улсын гадаад бодлого, олон улсын харилцаа”, “БНМАУ энх тайван хамтын ажиллагааны төлөө тэмцэж байгаа нь”, “БНМАУ-ын гадаад бодлогыг судлах асуудалд”, “1925-1927 оны Хятадын хувьсгалын үед дотоод Монголын Ардын Хувьсгалт Намаас явуулсан зарим ажиллагаа” зэрэг олон арван эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл туурвижээ.

С.Ишдорж орос, англи хэлтэй, тухайн үедээ онслын өндөр мэдлэгтэй, нягт нямбай боловсон хүчин байсан учир МАХН-ын төв аппарат болон төр засгийн чухал албанд дайчлагдан, дээд байгууллагын үүрэг даалгавараар цаг зав, мэдлэг чадвараа дайчлан тухайн үеийн үзэл суртлын үүднээс судалгааны бүтээл олныг нийтлүүлсэн юм. Гэвч энэхүү ахмад эрдэмтний судалгаа социализмын үеийн Монгол улсын түүхэн замнал, МАХН-ын үзэл бодол, гадаад бодлого ямар байдал төлөвтэй байсан зэрэг бодит байдлыг ойлгоход тодорхой хэмжээгээр үнэ цэнтэй хэвээр байгааг үгүйсгэх аргагүй юм.

80-аад оны сүүлчээс эхлэн С.Ишдорж Монгол улсад өрнөсөн ардчилал, шинэчлэлийн шинэ уур амьсгалыг халуун дотноор хүлээн авч судалгаа шинжилгээний ажилд зөвхөн марксизм, ленинизмын байр сууринаас хандах биш олон ургальч үзлийн үүднээс түүхэн үйл явдалд илүү бодитой хандахыг эрмэлзэж ирсэн нь тодорхой харагддаг. Ялангуяа 90-ээд оны эхээр түүний бичсэн Хятад, АНУ судлалын холбогдолтой бүтээлд энэ нь нэн тод харагддаг.

Эрдэмтэн С.Ишдорж Монголын АНУ судлалын төвийг үндэслэн байгуулахад чухал хувь нэмрээ оруулж, тэрхүү төвийн анхны зохицуулах нарийн бичгийн даргаар дараа нь зөвлөхөөр ажиллаж байсан билээ. Энэ үедээ С.Ишдорж АНУ-ын түүх, олон улсын харилцааны хэд хэдэн дорвитой өгүүлэл бичсэн юм. Түүний бичсэн “Кремлээс ногоон гэрэл ассаны дараа...” хэмээх судалгаанд ХХ зууны Монгол, Америкийн харилцааны түүхийн гол асуудлуудыг нарийвчлан нягталжээ. Тэрбээр энэ өгүүлэлдээ Монгол улсыг НҮБ-д элсэх үед АНУ-ын байр суурь ямар байсан, Монгол улс, АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтоох явц удааширсаны зарим шалтгааныг тодруулснаас гадна үзэл сурталжсан намч улс төрийн дарангуйллын үед Америкийн дипломатч С.Сокобиныг тагнуул туршуул байсан гэж хардаж сэрдэж байсан бол С.Ишдорж түүний үйл ажиллагааг өөрөөр харж үнэлэх баримт гаргаж тавьжээ.

Мөн түүний бичсэн нэлээд хэдэн өгүүлэлд ардчилсан шинэ Монголын талаарх АНУ-ын бодлого байр суурийг буурьтай судлан бичсэн байдаг. С.Ишдорж нь 1994 онд “АНУ бүрэлдэн тогтсон түүхээс” хэмээх томоохон түүхэн найруулал бичиж тус хүрээлэнгийн АНУ судлалын төвөөс эрхлэн гаргадаг Америк судлалын сэтгүүлд цувралаар хэвлүүлсэн юм. Энэ бүтээл нь Америк тивийг Христофер Колумба нээсэн үеэс 19-р зууны дунд үе хүртэлх хэдэн зуун жилийн ээдрээ түвэгтэй түүхийг Монголын уншигчдад танилцуулсан анхны бүтээл байлаа.

Нэн хөдөлмөрч нямбай энэ эрдэмтний гараас гарсан бүтээл тооны хувьд цөөхөн гэдээ ч чамбай чанартай байдгийг мэргэжил нэгт нөхөд нь андахгүй.

Тэрбээр “Ю.Цеденбал. Исторический путь развития социалистической Монголии”. /42 хх/, УБ. 1976, “Великий Октябрь и международных отношения нового типа” /28 хх/, УБ, 1978, “Маоизм и национальный вопрос” /24 хх/. УБ. 1980, “БНХАУ-ын түүхийн товч найруулал” УБ, 1984 зэрэг томоохон 10 гаруй эрдэм шинжилгээний бүтээлийг хянан найруулж, алдаа малагийг нь ариутган шүүжээ. С.Ишдорж эрдэмтэн нөхдийнхөө туурвисан бүтээлийг хянан үзэж санал бодлоо хэлэхдээ нэн ханатай бөгөөд онож хэлдэг. Тэрбээр бичсэн аливаа зүйлийг бага том гэхгүй нягтлан үзэж найруулга үг үсгийн алдааг нэн гярхай олдог, найруулга муутай үг үсгийн алдаатай юмыг хатуу шүүмжилдэг нэгэн билээ. Ахмад эрдэмтэн С.Ишдорж нь нягт нямбай хатуу чанд шаардлагаараа тус хүрээлэнгийн олон залуу ажилтнуудыг дадлагажуулан үлгэр дууриал өгсөн юм.

Энэ онд эрдэмтэн С.Ишдоржийн 75 насны ой тохиож байгаад Монгол Улсын ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдмийн хамт олон чин сэтгэлийн баяр хүргэж, эрүүл энх, урт удаан наслахыг хүсэн ерөөж байна.